

Вестибо 8мг ба 16мг шахмал

Ветагистин

Бүртгэлийн дугаар:

1 шахмалд: үйлчлэгч бодис:

Вестибо 8мг-д :Бетагистиний дигидрохлорид 8мг

Вестибо 16мг-д: Бетагистиний дигидрохлорид 16мг

Туслах бодис: повидон, бичил талст целлюлоза, лактозын моногидрат, хуурай коллоид кремнийн хоёрч исэл, кросповидон, стеарины хүчил тус тус агуулагдана.

Эмийн хэлбэр: Шахмал.

Фармакологийн үйлдэл:

Толгой эргэх шинжийг намдаах бэлдмэл.

Вестибо нь тархины зарим бүс болон дотор чихэнд байрлах өвөрмөц рецепторт (гистамины H_1 ба H_3) үйлчилнэ. Бэлдмэл бичил эргэлт ба хялгасан судасны нэвчимхий чанарыг сайжруулах бөгөөд тэнцвэрийн эрхтний эндолимфийн даралтыг хэвийн болгоно.

Вестибо нь зүрхний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй ба харин зарим тохиолдолд артерийн даралтыг бага зэрэг бууруулж болно.

Бэлдмэлийн нөлөөгөөр толгой эргэх шинж багасан давтамж нь цөөрөх бөгөөд чих шуугих шинж багасаж сонсгол сайжирдаг (сонсгол муудсан тохиолдолд).

Хэрэглэх заалт:

Вестибо бэлдмэлийг дараах шинж бүхий Меньерийн өвчний эмчилгээнд хэрэглэнэ.

- Толгой эргэх (дотор муухайралт ба бөөлжилт бүхий)
- Дүлийрэх (сонсголын өөрчлөлт)
- Чих шуугих

Түүнчлэн тэнцвэрийн эрхтний өвчнөөс шалтгаалсан толгой эргэх эмгэгийн шинж тэмдгийн эмчилгээнд хэрэглэнэ.

Бэлдмэлийг хэрэглэхээс өмнө зайлшгүй мэдэх мэдээлэл:

Цээрлэлт:

Вестибо-г бетагистиний дигидрохлорид болон бэлдмэлийн найрлага дахь туслах бодисуудад хэт мэдрэг (харшил) хүмүүст хэрэглэхийг цээрлэнэ.

Онцгой болгоомжлол!

Бэлдмэлийг дараах тохиолдолд болгоомжтой хэрэглэнэ.

- Шархлаа өвчтэй хүмүүс. Учир нь эмчилгээний явцад хоол боловсруулах замын хямрал (цээж хорсох, халуу оргиж буй мэдрэмж төрөх, дотор муухайрах, ходоодны хямрал) үүсэх эрсдэлтэй.
- Гуурсан хоолойн багтраа, чонон хөрвөс, тууралт, харшлын гаралтай хамрын салст бүрхүүлийн үрэвсэл. Бетагистиний эмчилгээний явцад харшлын шинж гүнзгийрч болзошгүй тул харшилтай өвчтөнүүдэд эрсдэлтэй.
- Мигрень ба гистаминаар үүсгэгдсэн толгойн өвдөлт. Учир нь бетагистиний эмчилгээний явцад өвчин сэдэрэх аюултай.
- Гистамины эсрэг бэлдмэл (харшлын эсрэг бэлдмэл) хэрэглэж буй өвчтөн.

Феохромоцитомтой өвчтөнд бэлдмэлийг зөвхөн эмчийн хяналтан дор хэрэглэнэ. Учир нь бетагистин хавдраас ялгарах катехоламины чөлөөлөгдөлтийг ихэсгэн хүнд явцтай гипертонийн криз үүсгэж болзошгүй.

Эмийн харилцан үйлчлэл:

Вестибо-г гистамины эсрэг бэлдмэлтэй (харшлын өвчний эмчилгээнд хэрэглэдэг бэлдмэл) хамт хэрэглэхгүй.

Этилийн спирт, приметами́н, сульбу́тамол нь бетагистиний үйлдлийг хүчжүүлнэ.

Тусгай бүлэг өвчтөнд зориулсан онцгой анхааруулга!

Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ:

Амьтанд хийгдсэн судалгаагаар бэлдмэл үр удамд гэмтээх нөлөө үзүүлдэггүй байна. Жирэмсэн эхэд аюулгүй эсэх нь тогтоогдоогүй тул бэлдмэлийг жирэмсэн үед хэрэглэхгүй.

Цусны сийвэнгийнхтэй ойролцоо хэмжээгээр хөхний сүүтэй ялгарна. Хөхүүл хүүхдэд сөргөөр нөлөөлсөн талаар мэдээлэл байдаггүй. Хөхүүл үед бэлдмэлийг хэрэглэхээс зайлсхийнэ.

Тээврийн хэрэгсэл жолоодох ба техниктэй ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:

Бетагистин нь анхаарал төвлөрүүлэх чадварт нөлөөлдөггүй. Зарим үед эмчилгээний явцад нойрмоглох шинж илэрч болзошгүй. Иймээс автомашин жолоодох ба техниктэй ажиллах чадвар түр зуур өөрчлөгдөж болзошгүй.

Туслах бодистой холбоотой мэдээлэл:

Бэлдмэлийн найрлагад лактоза агуулагддаг учир вестибо-г лактоз зохидоггүй хүмүүст хэрэглэхэд тохиромжгүй.

Бэлдмэлийн зөв хэрэглээтэй холбоотой мэдээлэл:

Хэрэглэх арга, тун:

Бэлдмэлийн тунг өвчтөн бүрт тохируулж сонгоно.

Бэлдмэлийг хооллох үед хэрэглэнэ.

Өвчний зовиураас хамаарч эмчлэгч эмч таны эмчилгээнд шаардлагатай тунг тогтооно.

Насанд хүрэгсдэд:

Хоногт 24-48мг тунгаар хэрэглэх ба хоногийн тунг 2-3 хувааж хэрэглэнэ.

Шахмалыг хооллох үед хэрэглэнэ.

Хүүхдэд:

Бэлдмэлийг 18 хүртлэх насны хүүхдэд хэрэглэхгүй.

Энэ бүлгийн эмийг хүүхдэд хэрэглэх талаар бүрэн судлагдаагүй.

Зарим өвчтөнд 14 хоногийн ээлж эмчилгээний дараа өвчний сайжрал илэрдэг.

Хэрэв та бэлдмэлийг уулгүй мартаж өнгөрөөсөн бол түүнийгээ дараагийн эм хэрэглэх цагтаа хэрэглээрэй.

Тун хэтэрсний улмаас илрэх нөлөө:

Тун хэтрэх үед дотор муухайрах, бөөлжих, хоол боловсруулах замын хямрал илрэх, тэнцвэргүйдэх, таталдах зэрэг шинж илэрнэ. Хордлогын үед бөөлжүүлэх ба ходоодны гуурсны тусламжтайгаар ходоодны агууламжийг яаралтай гадагшлуулж угаана. Түүнчлэн хордлогын эсрэг тохирсон эмчилгээ хийнэ.

Гаж нөлөө:

Эмчилгээний явцад дараах гаж нөлөө илэрч болно.

- ТМС-ийн зүгээс: нойрмоглох, ядарч сульдах, толгой өвдөх.
- Арьсны зүгээс: тууралт, загатнаа.
- Хоол боловсруулах системийн зүгээс: ходоод орчмоор бага зэрэг эвгүйрхэх шинж илрэх ба бэлдмэлийг хооллох үед хэрэглэж зайлсхийнэ.

Эмийн хэлбэр, савлалт:

8мг шахмалыг 10 ширхгээр хөнгөн цагаан фольгитой блистертэй гаргаж 3 блистерийг хэрэглэх зааврын хамт цаасан хайрцганд савлаж гаргана.

16мг шахмалыг 10 ширхгээр хөнгөн цагаан фольгитой блистертэй гаргаж 3 блистерийг хэрэглэх зааврын хамт цаасан хайрцганд савлаж гаргана.

Хадгалалт:

25°C-аас доош хэмийн хүүхэд хүрэхээргүй газар хадгална.

Хадгалах хугацаа:

Үйлдвэрлэснээс хойш 3 жил. Савлалтан дээрх хүчинтэй хугацаа дууссанаас хойш бэлдмэлийг хэрэглэхгүй.

Эмийн сангаас олгох журам:

Жороор олгоно.